



СУРАЛЦАГЧИЙГ АМЖИЛТТАЙ СУРАЛЦАХАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛЭЭС

МУБИС - ийн докторант Б.Лхамноржмоо

Abstract

Things which affect pupils to study successfully.

1. *Every lesson has to be taught efficiently and teachers should consider on improvement of quality. Due to teachers taught their lesson efficiently, number of pupils who don't understand their lesson is increasing.*
2. *Teachers should work with pupils closely and understand pupils from the bottom of their hearts as well as communicate with pupils in a good way. By understanding each other. There will a progress appear in other words.*

- Change ideas*
- Change method*
- Change communication*

Дэлхийн улс орнууд хөгжлийг үзэх үзэл баримтлалдаа өөрчлөлт оруулж хүний хүчин зүйлсэд тулгуурлан хөгжлийн бодлогоо тодорхойлодог болсон байна.

Нийгмийн хөгжил, улс орон, дэлхий нийтийн хөгжлийн хурдацтай энэ үед хэрхэн хөл нийлүүлэх түүнээс хоцрохгүй байхыг хичээх хэрэгтэй болоод байна. Энэ бүгдийг хэн рүү ч хичээх гэсэнгүй хэнд ч даатгах гэсэнгүй бид өөрсдөө хамтын хүчээр шийдэж чадах ёстой. Үүнтэй зэрэгцэн багш эцэг эх сурагчаас үйггүй хөдөлмөр хамтын ажиллагаа өндөр үр чадвар хичээл зүтгэл хамгаас чухал бөлгөө.

Өнөөгийн суралцагчийн суралцахуйд сурч буй байдал нь өнөөгийн болоод ирээдүйн нийгмийн шаардлага хангахуйцаар байж чадаж байна үү? үгүй юу? гэдэгт санаагаа чилээлээ. Бидний сургаж буй суралцагчдын нэг хэсэг нь амжилттай сайн сурч нэг хэсэг нь буюу дийлэнх олонх нь санаанд хүрэхүйцээр суралцаж чадахгүй байна. Тиймээ монгол хүүхэд бэлэн хоол, бэлэн хувцас, бүх зүйл бэлэн, бэлэнчлэх сэтгэлгээнд сурчихсан өөрийгөө хөгжүүлэх дайчлах сэтгэлгээ байхгүй амар хялбар аргаар амьдрахыг хүсэгчид болж хувираад байгаа нь томчууд бидний буруу билээ.

Хүүхдүүдийн сонирхож хийж буй ажил нь РС тоглох, телевиз үзэж, мессежээр харьцаж бөгөөд өдрийн ихэнх цагийг барж байгаа нь судалгаануудын дүгнэлтээс тодорхой харагдаж байна. Сурч хөгжих үеэ иймэрхүү байдлаар өнгөрөөж байгаад харамсаж байдаг.

- Үүнд олон шалтаг шалтгаан байна.
- Сургуулийн анги дүүргэлт их
- Эцэг эхийн анхаарал халамж
- Нийгмийн ядуурал, эдийн засгийн хямрал
- Багшийн үр чадвар
- Суралцагчийн идэвх оролцоо гэх мэт
- Энэ бүгдээс гарч болох гарцыг хайлаа.

Наад захын хүүхэд амьдралд өөрийгөө авч явах чадвартай байх, тал бүрийн чадвартай хүмүн төлөвшүүлэх шаардлагатай байгаа. Гэвч бэлэнчлэх сэтгэлгээтэй залуу,

хуурч мэхэлж хялбар аргаар дүн авах гэсэн, толгой дундуур хүмүүс олшоод байгаа нь илэрхий харагддаг. Өнөөдөр эцэг эх, багш хүүхэд хичээл хийхээ болилоо, гэрийн даалгавар хийхгүй байна, залуу болсон, РС тоглож байна гэх мэтээр халаглан ярих нь олонтой. Энэ муу зүйлээс ирээдүй хойч үеэ хэрхэн салгаж тэд нэгэн цагт өөрийгөө хөгжүүлэх өөр зүйлийн араас явдаг болгох вэ?

Монголын ирээдүй хүүхэд багачууддаа багаас нь хэрхэн загас барих аргыг нь яаж зааж өгөх вэ гэдгийг шийдэх хэрэгтэй байна. Үүний тулд багш сурагч эцэг эх гурвын нэгдсэн нэг сэтгэл, нэг зорилго хамтын ажиллагаа тэдний нэгдсэн арга барил хамгаас чухал болох нь харагдаж байна.

Боловсрол эзэмших суурийг буюу бага боловсролыг сайн тавьсан цагт сая хүүхэд хөгжих боловсрох арга ухаанаа олж сайн хүн, боловсорсон хүн болж чадна.

Суралцагч өөрийнхөө ирээдүйн төлөө санаа зовдог, санаа тавьдаг тийм сэтгэлтэй болсон цагт энэхүү муу зүйлийг халж гэж чадна. Өөрөөр хэлбэл, сурагчийн өөрийн сурах идэвх оролцоо, багш эцэг эхийн дэмжлэг оролцоо нэгтгэх хэрэгтэй байна. Сургалтын үйл ажиллагаанд оролцож буй суралцагч, түүний багш эцэг эх бүгд хариуцлага үүрдэг байх хэрэгтэй.

Боловсролын хуулинд эдгээр багш, эцэг эх сурагчийн эрх, үүргийг тодорхой тусгаж өгсөн боловч хараахан түүнийг бүрэн дүүрэн ухамсарлаж ажил хэрэг болгодог нь ховор байна. Цаасан дээр бичигдсэн хэрэгжихгүй хууль байгаад байна. Хүн бүрийн сэтгэлгээнд хуулийг дээдэлдэг, эрхэмлэдэг болгосон цагт сая биелэх байх. Нэг талаас, эцэг эх хүүхдээ сайн хүн болгох гэж сургуульд өгдөг, нөгөө талаас, багш сурагчаа сайн сургах гэж мэрийдэг. Гэвч дийлэнх олонх дээр энэ хүсэл хараахан сэтгэлд хүрэхүйцээр биелж чадахгүй байна. Ямар нэг болох болохгүй зүйл гарвал хүүхэд буруутан болдог. Яагаад сул сураад байна? Яагаад идэвхгүй байна гэдэг учрыг олох нь чухал байна. Энэ учрыг олбол бид гарах гарцыг хайх амархан. Өнөөдөр муйхар аргаар л хамаг бурууг хүүхдэд тохоод миний ажиллаж буй аргаас болоогүй биз гэж бодсон эцэг эх, багш тун ховор. Хаа хаанаа арга барилаа өөрчлөх цаг аль хэдийн хаалга тогшиж байхад бидний нэг хэсэг учраа олохгүй явсаар цаг урсаж, дутуу боловсорсон ирээдүй төрж гарсаар л байна.

Багш нарын аргагүй арга барилыг өөрчлөх гэж багагүй ажлыг хийсээр ирсэн хийсээр ч байна. Гэвч энэ нь монголын багш нарыг массаар нь хамарч чадахгүй хэдхэн идэвх зүтгэлтэй, сэтгэлтэй нэгээхэн хэсэг л хамрагдаж түүнийг хэрэгжүүлж байна. Бусад нөгөө хэсэг нь номоо барьж ороод л унш, бич, бод гэж хүүхдийг хөгжүүлэх зүйлийг хараахан бүрэн дүүрэн хийхгүй байгаад сэтгэл эмзэглэж явдаг. Багшийн үйл ажиллагаанд сургуулийн захиргаа, сургалтын менежер хяналт тавихдаа энэ багш хүүхдийг хөгжүүлэх зүйл хийж байна уу, үгүй юу гэдэгт тавих хяналтыг өөр өнцгөөс харах. Өөрөөр хэлбэл, багшийг эзэмшсэн боловсрол дээр нь нэмээд ажлын байранд нь жинхэнэ



утгаар нь хөгжүүлэх хүмүүс менежерүүд. Менежер багшийн байнгын туслагч, дэмжигч, зөвлөгч байх. Багшийг хүүхдийн дотоод ертөнцөд орж хэрхэн ажиллаж буйг хянаж зөвлөн тусалж баймаар санагддаг.

Нөгөө талаас, бид шалгалт шүүлэг аваад хангалтгүй байвал багшийг чичлээд л орхидог. Үүний оронд яагаад ийм хангалтгүй үнэлгээ гарав, бид хаанаа алдав гэдгийг хамтарч олдог байх хэрэгтэй. Багш ажилдаа нарийн оношилгоо хийдэггүй учир ужиг өвчин архагшдаг. Өөрөөр хэлбэл, хүүхдийн дотоод ертөнцийг нээж чадахгүй бол амжилт гарахгүй гэж хэлэх гээд байна. Хоцрогдол байсаар л байх болно.

Шалгалт шүүлэг аваад сайн муугаа яриад орхих биш. Цаашид яаж хэрхэн ажиллах, хоцрогдлыг хэрхэн арилгах талаар дахин аргагүйгээ боловсруулж ажилладаг баймаар байна. Хүүхдийн ойлгоогүй, дутуу ойлгосон зүйлийг арилгаж байж дараагийн шинэ мэдлэгийг олгодог байх. Өнөөдөр энэ дасгалыг хийсэн маргааш нөгөө дасгалыг нь заавал хийх мэтээр ойлгож болохгүй. Өмнөх ойлгохгүй зүйлийг нь заавал ойлгуулж дараагийн зүйлийг ойлгуулах нь чухлаас чухал байна.

Ойлгоогүй мэдэхгүй зүйлүүд хураагдсаар хоцрогдол, нөгөө муу нэртэй суралцагч бий болгоод байна.

Сурч чадахгүй өөрийгөө дайчлахгүй байгаа сурагч хариуцлагаа үүрдэг, сурагчаа сургаж чадахгүй байгаа багш хариуцлагаа үүрдэг, хүүхдэдээ анхаарал шаардлага тавьдаггүй эцэг эх хариуцлагаа хүлээдэг болох. Ийм тогтолцоонд шилжиж үүрэг хариуцлагыг өндөржүүлэх хэрэгтэй байна. Энэ нь хүссэн хүсээгүй зайлшгүй шаардлага болон урган гарч байна.

Төрөөс боловсролд хандах хандлага шаардлага өөрчлөгдөж тэр хэрээрээ шинэчлэл хийхээр ажилласаар байгаа боловч бүтээгдэхүүний чанарт ахиц хангалтгүй байгаа нь нийгэм цаг үеийн шаардлагад нийцэхгүй байна. Тухайн хүний боловсролоос авсан мэдлэг нь түүний нийгэмд эзлэх байр суурь тодорхойлогдож хүний хөгжил өндөр түвшинд хүрч хүмүүн хөгжсөнөөр нийгмийн хөгжлийн хурдцад ахиц гарах нь гарцаагүй. Энэ бүгдийн эцэст хүмүүсийн амьдралын аз жаргалтай сэтгэл өөдрөг амьдрах амьдралын баталгаа нэмэгдэнэ.

Үүнд бид эхлээд багш, эцэг эх, сурагчийн сэтгэлгээг өөрчлөхгүйгээр боловсрол урагш гишгэх нь тун удаашралтай байна.

Тиймээ тэдний үүрэг хариуцлагыг өндөр байлгах нь чухал байна. Хуучин энэ байдлаасаа тун хурдан салахгүй бол төрөөс сүл цалин хүртэгчид олширч, сүл сурлагатан олон болж, дундуур дулимаг зүйлээр нийгэм дүүрч боловсрол хүнийг боловсруулах биш түүхий хүмүүс гаргаж, нийгэм хөгжих биш эмгэнэлт байдалд хүрэх вий.

Энэ байдлаас бид хамтын хүчээр гарч чаднаа. Багш хүн хэн байх, ямар байхыг хуульчилж өгөөд орхих биш эргээд хариуцлага тооцдог үнэлдэг үнэлгээ маш чухал байна. Иймд үнэлгээ эргээд хариуцлага тооцох систем нь нарийн баймаар санагддаг. Ингэсэн тохиолдолд багш сайн ажиллаж чадна. Багшийн ажлын байрны тодорхойлолт, багшийн ажлыг үнэлж дүгнэх журам гэх зүйлүүд гаргасан боловч ажлын чанарт нөлөөлөхүйцээр байгаа нь харагдахгүй байна.

Энэ нь багшийн ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ зэрэгт тодорхой тусгасан байдаг. Багшийн ажиллах эрхзүйг нотлох баримтыг ийнхүү тод томруун зааж өгсөн боловч гэрээ хийхдээ бараг уншдагч

гүй хөдөлмөрийн гэрээнд гарын үсэг зураад эргэж түүнийг сөхөж хардагч үгүй. Намар гэрээ байгуулаад хавтсанд хийгээд цааш нь тавьчихдаг. Хааяа нэг эргэж хардаг уншдаг байгаасай. Учир нь багш нар заримдаа гол ажлаа мартсан явдаг.

Жишээ нь: Сургалтын чанарыг тасралтгүй ахиулах.

Ажиллаад л байдаг, ажиллаад л байдаг үр дүн нь маруухан байдаг. Хүүхэдтэй ганцаарчилж ажиллах гэсэн ойлголт үгүй болсон. 2-3 ээлжээр хичээллэдэг давтах цаг анги танхим ч байддаггүй бололтой. Мөн нэг ангид 40-50 сурагч сурдаг. Анги дүүргэлт их байгаа нь хүүхэд нэг бүрт хүрч ажиллана гэсэн ойлголт байхгүй болсон байна. Энэ бүгд хүндрэлээс гарахын тулд:

1. Чадвартай боловсролтой сурагч бэлтгэж гаргахын тулд ямар ч багшийн ээлжит хичээлийн чанар чансаа маш чухал гэдэгтэй санал нийлж байсан хүн олон байсан.

Ээлжит хичээлийг хангалтгүй зааснаар хичээлээ ойлгодоггүй сурагчийн тоо олширч хоцрогдол гардаг.



Үүнээс гарч болох нэн тэргүүний гол арга нь багшийн ээлжит хичээлийн чанарыг сайжруулах нь чухал байна. Ээлжит хичээлийг хэдий чинээ чанартай бүтээлчээр сайн заана төдий чинээ хүүхэд хичээлээ сайн ойлгож хоцрогдол багасна.

Багшийн хайнга заасан хичээлийг хүүхдүүд дулимагхан эзэмшсэн байдаг. Багш би тэндээ л алдсан даа гэдгээ мэддэг ч алдаа давтагдсаар л байдаг. Алдсан алдаагаа хэрхэн засах талаар үйл ажиллагаагаа чиглүүлэх хэрэгтэй байна. Сургуулийн удирдлага, багш үүн руу үйл ажиллагаагаа сайн чиглүүлсэн цагт бидний ажилд амжилт гарна. Хичээлийг хэрхэн үр дүнтэй заах вэ? Багш нараас авсан санал асуулга: Та хичээлдээ шинэлэг арга барилыг, бүтээлч аргуудыг хэрэглэдэг үү?

А.Байнга Б.Заримдаа В.Огт үгүй





Иймд багшийн бас нэг анхаарах зүйлийн нэг, ажилдаа мөрдлөгө болгох зүйлийн нэг нь:

Сэтгэлгээгээ өөрчлөх

Аргазүйгээ өөрчлөх

Харьцаагаа өөрчлөх хэрэгтэй байна.

Сурагчийнхаа дотор орж, сурагчаа ойлгож түүнийг зүрх сэтгэлээрээ мэдэрсэн багш сурагчийг амжилттай сургаж чадна. Ер нь сурагчаа ойлгож илэн далангүй байх нь буруу хийх гэж байсан алхмын ард гарч чадна.

Баримт: Нэгэн жишээ дурдъя 1990 – ээд оны үе манай ангийн даалгавар хийдэггүй нэгэн сурагч сурлага нь ахидаггүй. Багш даалгавраа хий гэж загнасаар сурагч хийдэггүй улам муудсаар. Учрыг нь олох гэж нэг өдөр хичээлийн дараа ганцаарчлан уулзлаа. Яагаад даалгавар хийхгүй байгаа учир шалтгааныг асуулаа. Эхэндээ юу ч ярьдаггүй.

Даалгавар хийхгүй яваад байвал чи эцэст нь муу хүн болно гэдгийг хэлэв. Хэсэг хугацааны дараа ярьж гарав.

Ангид ирэхээр багш та даалгавар хийсэнгүй гэж загнадаг. Гэрт харихаар ээж аав 2 дүүгээсээ дор гэж загнадаг. Энэ бүгдэд дургүй хүрдэг. Дүүдээ атаархдаг. Хичээл хийх сонирхол байдаггүй гэв.

Би энэ хүүхдийн ярианаас буруу алхам хийснээ ухаарч өөртөө дүгнэлт хийн, тэр охиноос уучлалт гуйн цаашид яах тухай илэн далангүй ярилцсан. Сурагчаасаа уучлалт гуйх хамгийн их хүндэтгэл болдгийг тэгэхэд ойлгосон.

Намайг уучлалт гуйснаас хойш тухайн охин нээлттэй болж, багштайгаа улам дотносож хичээлдээ дуртай болж илэрхий сайжирч ирсэн. Сүүлдээ шүлэг зохиож, би түүврийг нь хэвлүүлж өгч бөөн баяр болж билээ. Одоо МУИС-ийн сэтгүүлчийн ангийн 2-р курсийн оюутан болсон.

Багш сурагчтай буруу харьцах, буруу шийдвэр гаргаснаар хүүхдийн ирээдүйг нь ч хохироодог бас нэг жишээ байна.

Баримт: Гадаадад сурч байгаад ирсэн нэгэн хүү гадаад хэлний хичээлдээ англи маш сайн байлаа. Багш тухайн сурагчийн хор шарыг майжин чи бид хоёрын тоо боддог ч юу л бол, хэлээрээ л яв гэж хэлсний хариуд тухайн хүүхэд тооны ангид шалгалт өгөн нягтлан болохоор суралцаж байгаа. Гэвч тэр хүүхэд хэлээрээ явсан бол илүү их амжилтанд хүрэх байсан. Одоо тоогоор явж нягтлан болох гэж байгаа ч тийм ч сайнгүй байгаа.

Иймд багш нар хэлэх үгээ хүртэл бодож хэлж байхгүй бол хүүхдийн ирээдүйг буруу тийш нь эргүүлж хохироох магадлал байна гэдгийг энэ жишээнээс ойлгосон байхаа.